



ХЭНТИЙ АЙМГИЙН
ӨМНӨДЭЛГЭР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 11 сарын 17 өдөр

Дугаар А/318

Өмнөдэлгэр сум

Хурдан морины уралдаан зохион байгуулахыг
хориглох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дахь заалт, Монгол Улсын Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 57 дугаар тогтоол, 2025 оны “Хурдан морины уралдааны талаар авах зарим арга хэмжээ”-ний тухай 41 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2024 оны “Хурдан морины уралдаан зохион байгуулахыг хориглох тухай” А/619 дугаар захирамж, Хөдөлмөр нийгмийн хамгааллын сайдын 2022 оны А/122 дугаар тушаалаар баталсан “Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалт”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд хурдан морины уралдаан, сунгаа, үсэргээ, бооцоот уралдаан зохион байгуулахыг 2026 оны 05 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд хориглосугай.

2. Захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг Хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан (Г.Мөнхзул)-д, хяналт тавьж ажиллахыг хэсгийн төлөөлөгч (Д.Жамъяандорж)-д үүрэг болгосугай.



Б.ЭНХТӨР

2325310531